



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/209

Улаанбаатар хот

Журамд өөрчлөлт оруулах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.8.3, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.23 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн сайдын 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн “Журам батлах тухай” А/189 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтын 1.2.1 дэх заалтыг “Төрийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлд ажиллах олон нийтийн төлөөллийг сонгон шалгаруулах хороог Сангийн яам, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар, тухайн эмнэлэг, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас тус бүр нэг, Эрүүл мэндийн яамнаас хоёр, нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулна”, 1.2.2 дахь заалтыг “Орон нутгийн өмчит нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлд ажиллах олон нийтийн төлөөллийг сонгон шалгаруулах хороог тухайн аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, тухайн эмнэлгээс тус бүр нэг, Эрүүл мэндийн газраас хоёр, Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас хоёр, нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулна” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Энэхүү тушаалыг Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн газрын дарга нарт хүргүүлэхийг Бодлого төлөвлөлтийн газар /Д.Төмөртоогоо/-т даалгасугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

080688